Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүрээмарал сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрөөс Стандарт хэмжилзүйн газрын нэгдсэн "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Хүрээмарал сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 345,143.0 мянган төгрөг буюу 24.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

**Хүрээмарал сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
<b>Б</b>						
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	73,389.00	5.2%	200,061.60	11.5%	126,672.60	172.6%
Мөнгөн хөрөнгө	0	0.0%	0	0.0%	-	
Авлага	5,649.30	0.4%	93,066.90	5.3%	87,417.60	1547.4%
Урьдчилгаа		0.0%		0.0%	-	
Бараа материал	67,739.70	4.8%	106,994.70	6.1%	39,255.00	57.9%
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,326,839.30	94.8%	1,545,309.70	88.5%	218,470.40	16.5%
Үндсэн хөрөнгө	2,227,609.10	159.1%	2,506,610.50	143.6%	279,001.40	12.5%
Хуримтлагдсан элэгдэл	(900,769.80)	-64.3%	(961,300.80)	-55.1%	(60,531.00)	6.7%
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,400,228.30</b>	<b>100%</b>	<b>1,745,371.30</b>	<b>100%</b>	<b>345,143.00</b>	<b>24.6%</b>
Өр төлбөр	199.20	0.0%	109.60	0.0%	(89.60)	-45.0%
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,400,029.10	100.0%	1,745,261.70	100.0%	345,232.60	24.7%
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,400,228.30	100.0%	1,745,371.30	100.0%	345,143.00	24.6%

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл байхгүй.

Авлагын дансны үлдэгдэл 93,066.9 мянган төгрөг болж 87,417.6 мянган төгрөг болж өссөн нь нэмэлт санхүүжилтийн дансанд сангийн сайдын тушаалаар сургууль, соёлын төвд хөрөнгө худалдан авах зориулалтаар олгогдсон бөгөөд худалдан авах ажиллагааны тендер зарлах хугацаа хоцорсны улмаас санхүүжилтийг буцаан төвлөрүүлж авлагаар бүртгэсэн. Бусад зардлын тооцооны авлагын үлдэгдэл олон жилийн өмнө үүссэн мотор түрээсийн 3,066.9 мянган төгрөгийн авлага бөгөөд шүүхийн байгууллагад ханддаг боловч эзэн холбогдогчгүй гэх шалтгаанаар буцаагддаг. Дээрх авлага нь санхүүгийн тайлангийн аудитын явцад барагдсан болно.

Бараа материалын дансны үлдэгдэл 106,994.7 мянган төгрөг болж 39,255.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн хөрөнгөөр 127,156.1 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, Хүрээмарал сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2023.12.16-ны өдрийн хурлын хуралдааны 10/04 дугаар "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгүүдийг бүртгэлд авах тухай" тогтоолоор бусад хангамжийн материалд 8,400.0 мянган төгрөгийн бараа материал, 29,428.4 мянган төгрөгийн малыг үнэ төлбөргүй хүлээн авсан нь бараа материал дансны үлдэгдэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Нийт 125,729.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,506,610.5 мянган төгрөг болж 279,001.4 мянган төгрөгөөр өссөн нь 18,049.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил төсвийн хөрөнгөөр худалдан авсан, Баянхонгор аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2023.11.13-ны өдрийн захирамжаар 8,370.0 мянган төгрөгийн өртөг бүхий 3 ширхэг мотоцикл, Хүрээмарал сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2023.12.16-ны өдрийн хурлын хуралдааны 10/04 дугаар "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгүүдийг бүртгэлд авах тухай" тогтоолоор 16 нэр төрлийн 221,483.7 мянган төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, тус тогтоолын хүрээнд 5 нэр төрлийн үндсэн хөрөнгийн

67,390.6 мянган төгрөгийн сайжруулалт балансад бүртгэсэнтэй холбоотой 315,294.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023.02.13-ны өдрийн хуралдааны 13/08 тоот тогтоолоор 116 нэр төрлийн 36,292.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, балансаас хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 109.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оны бэлтгэн нийлүүлэгчтэй холбоотой өглөг бөгөөд нягтлан бодогч өөрчлөгдөж, харилцагч тодорхойгүйгээс тухайн онд өглөгийг барагдуулаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,745,261.6 мянган төгрөг болж 345,232.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан үр дүн 345,232.4 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 359,188.4 мянган төгрөг, нийт зарлагыг 359,188.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 63,843.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 423,031.8 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн хуваарьт 2023 оны 08 сард тодотгол хийж 227,217.2 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны зардлыг нэмж тодотгосон ба 180,761.8 мянган төгрөгийн зардлыг орон төсвөөс, 46,455.4 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр батлагдсан.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд орон төсвийн санхүүжилтээр 643,322.0 мянган төгрөг, өөрийн орлого, 549.3 мянган төгрөгийн нийт 673,871.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 30,849.1 мянган төгрөгийн давсан орлогыг орон төсөвт төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 613,022.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 613,022.2 мянган төгрөг буюу 94.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 13,249.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 2,560.0 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 7,115.6 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 3,284.6 мянган төгрөгөөр, томилолт зочны зардлыг 873.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 1,558.2 мянган төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний бусад зардлыг 7,435.5 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 1,149.6 мянган төгрөгөөр нийт батлагдсан төсвийг нийт 37,226.8 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	650,249,100.00	613,022,198.32	37,226,901.68	94.3%
2	80101 Үндсэн үйл ажиллагаа	450,033,800.00	427,653,727.14	22,380,072.86	95.0%
3	80106 баг жорооны ҮАЗ	110,277,400.00	106,557,578.18	3,719,821.82	96.6%
4	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	21,717,900.00	20,568,343.00	1,149,557.00	94.7%
5	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	44,604,000.00	44,604,000.00	-	100.0%
6	81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	16,104,000.00	13,094,250.00	3,009,750.00	81.3%
7	82212 Хур жог хаягдал, орчны бохирдол	7,512,000.00	544,300.00	6,967,700.00	7.2%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн сайдын тушаалаар давсан орлогоос 90,000.0 мянга, мал тооллогын зардал 1,500.9 мянга, цахим тендерийн 560.0 мянган төгрөг, хандив тусламжийн хүрээнд 10,263.5 мянган төгрөг нийт 102,324.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, огтоно устгалын зардалд 2,500.0 мянган төгрөг, засаг даргын а75 ангиллын зардалд 1,228.5 мянган төгрөг, үнэлгээний хорооны гишүүдийн урамшуулалд 715.0 мянган төгрөг, гэр бүл хөгжлийн сургалтанд 1,341.7 мянган төгрөг, малын тооллого хийхэд 1,250.9 мянган төгрөг, байгаль орчны менежментийн зардалд 5,000.0 мянган төгрөг, материал худалдан авахад 95.0 мянган төгрөг, 90,000.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж авлагаар тусгасан, 193.3 мянган төгрөгийг орон нутгийн дансанд буцаан төвлөрүүлж, нийт 12,131.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь 2023 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлаагүй бөгөөд түлш халаалтын зардалд нийт 24,430.6 мянга, гэрэл цахилгааны зардалд 7,300.0 мянган төгрөг батлагдсанаас Итгэлт мандал констракшн ХХК-тай дулаанаар хангах гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-тай цахилгаанаар хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүрээмарал сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны

12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүрээмарал сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 650,249.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,502.5 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,876.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тухайн байгууллага нь батлагдсан төсвийг нийт 37,226.8 мянган төгрөгөөр, гэрэл цахилгааны зардлыг 2,305.5 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 254.5 мянган төгрөгөөр хэмнэж төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн алдаа зөрчил байхгүй.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны хяналтаар зөрчил илрээгүй.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

##### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж аудитаар 25,849.5 мянган төгрөгийн 4 зөвлөмж, 990.0 мянган төгрөгийн төлбөрийн акт өгснийг төлбөрийн актыг 100% барагдуулж, зөвлөмжийн хэрэгжилт 83.25%-тай биелэгдсэн талаар тус байгууллагаас 2023 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 46 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна. Санхүүгийн тайланд бүртгэлтэй эзэн холбогдогч тодорхойгүй олон жил болсон 3,066.8 мянган төгрөгийн мотор түрээсийн авлага барагдуулах зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	990.0	1	990.0	100%
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	4	25,849.5	3	23,782.7	83.25%
<b>Нийт дүн</b>	<b>15</b>	<b>26,839.5</b>	<b>4</b>	<b>24,772.7</b>	<b>91.6%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,889.0 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрснээс зөрчил арилгах 5,889.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

#### 5.2 Албан шаардлага

1.Илрүүлэлт: Газрын албанаас ирүүлсэн судалгаагаар 228,976 м<sup>2</sup> 23 ширхэг газар эзэмших эрх олгогдсон байхад тус байгууллагын санхүүгийн тайланд 6910 м<sup>2</sup> 9 газар эзэмших эрх бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалт "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт авлага" нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ гэсэн заалтыг зөрчиж байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Шийдвэрлэсэн нь:** Газар эзэмших эрх олгогдсон газруудыг 2024.05.01-ны дотор санхүүгийн тайланд бүртгэж, зөрчлийг арилган албан шаардлагыг хүргүүлэв.

**2.Илрүүлэлт:** Сум дундын ойн ангиас 2023 оны 3 дугаар сард үнэ төлбөргүй олгосон 5,889.0 мянган төгрөгийн өртөг бүхий 500 боодол өвс, 60 шуудай хивэг, 60 шуудай тэжээлийг санхүүгийн тайланд орлого аваагүй зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.5 дахь “ Бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэлт:** Үнэ төлбөргүй ирсэн өвс, тэжээлийг орлого авч, зарцуулалтын тайлан гаргах албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж<sup>2</sup>

Зөвлөмж байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
-	-	-	-	-	-	-	-	-	-	-
-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Газар эзэмших 222,066 м2 12 газрыг санхүүгийн тайланд бүртгээгүй	1				1			
Сум дундын ойн ангиас үнэ төлбөргүй ирсэн өвс, тэжээлийн орлого аваагүй, зарцуулалтын тайлан гаргаагүй.	1	5,889.0			1	5,889.0		
Нийт дүн	2	5,889.0			2	5,889.0		

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
		0				0		
Дүн		0				0		

-----oO-----

<sup>2</sup> Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ"



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 169/А057/2006/БНА-2024/  
127/НА-СТА-ТШЗ

Номгон

Г Зөрчил арилгуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүрээмарал сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын тайланг тулган шалгахад Сум дундын ойн ангиас үнэ төлбөргүй олгосон 500 боодол өвс, 60 шуудай тэжээл, 60 шуудай хивэгийг орлого аваагүй зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.1 дэх "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үнэ төлбөргүй олгосон 5,889,000 /таван сая найман зуун наян есөн мянга/ төгрөгийн өвс, тэжээлийг санхүүгийн тайланд бүртгэн, зарцуулалтын тайлан гарган

5040512

зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>4</sup>.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүрээмарал сумын Засаг даргын тамгын газрын дарга С.Нархүү, нягтлан бодогч Б.Мэндбаяр нарт даалгав<sup>5</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>6</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Б.НАРАНЦЭЦЭГ



<sup>4</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>5</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>6</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 168 / А0571206 / БНА-2024 /  
127 / НА-СТА-ТМЗ /

1.

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүрээмарал сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын албанаас ирүүлсэн газрын судалгаатай санхүүгийн тайланд бүртгэлтэй газруудыг тулган шалгахад нийт 228,976 м2 газар эзэмших эрх олгогдсон байхад 6910м2 газар бүртгэлтэй, 222,066 м2 газрыг санхүүгийн тайланд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

5040510

1. Засаг даргын захирамжаар эзэмшүүлэхээр олгосон газруудыг санхүүгийн тайланд бүртгэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүрээмарал сумын Засаг даргын тамгын газрын дарга С.Нархүү, нягтлан бодогч Б.Мэндбаяр нарт даалгав<sup>2</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>3</sup>.**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Б.НАРАНЦЭЦЭГ



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно